


УИХ дахь эмэгтэйчүүдийн төлөөлөл

Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэх нь улс орны хөгжилд ахиц дэвшил гарах хамгийн том боломж юм. Сайн засаглалыг хөгжүүлж буй улс орон бүр эмэгтэйчүүдийн улс төр болон шийдвэр гаргах түвшний оролцоог нэмэгдүүлэх талаар анхааран ажиллаж, тэдний дуу хоолойг сонссон хамтран ажиллаж байна. Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлснээр ядуурал буурч, хүчирхийлэл багасаж, нийгмийн хоцрогдож буй асуудлууд шийдлээ олж, хүүхэд, эмэгтэйчүүдийн эрх хангагдах тэгш боломж бүрдэж чаддаг.


Монгол улс МХЗ-ын хэрэгжилтийг хангахын төлөө ажиллаж байгаа бөгөөд 2012 оны байдлаар Улсын Их Хурал дахь эмэгтэйчүүдийн эзлэх нь 14,47 хувьтай байна.



Тайлбар. 1992 оноос хойш УИХ-д сонгогдсон эмэгтэйчүүдийн эзлэх хувь

Жендэрийн эрх тэгш байдал – 2012 онд

- Жендэрийн эрх тэгш байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлд төрийн захиргааны төв байгууллага болон нутгийн захиргааны байгууллагын түвшинд эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн оролцоо 40/60 байхаар хуульчлан зааж өгсөн бөгөөд төрийн бүх байгууллагууд хуулийн энэхүү заалтыг хэрэгжүүлж байгаа талаар жил бүр 2 дугаар сарын 10-ны дотор тайлангаа Жендэрийн Үндэсний Хороонд ирүүлж байх үүрэгтэй.
- УИХ-ын Сонгуулийн дараах Шинэчлэлийн Засгийн газрын танхимд 3 эмэгтэй сайд ажиллаж байгаа нь өмнөх Засгийн газрын танхимтай харьцуулбал 2 сайдаар нэмэгдсэн.
- 2012 оны Нийслэл, Аймаг, сум дүүргийн ИТХ-ийн сонгуулийн дүнгээс үзэхэд Аймаг, Нийслэл, дүүргийн ИТХ-ийн дарга, Засаг даргаар нэг ч эмэгтэй хүн сонгогдож, томилогдсонгүй.
- Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд жендэрийн болон бусад хүчин зүйлийг харгалзан тэгш боломжийг бүрдүүлэх ямар нэгэн хуулийн зохицуулалт, квот байхгүй байна.



Тайлбар. 2012 оны 12 дугаар сар 21 байдлаар сумын ИТХ-ын мэдээ эцэслэн нэгтгэгдээгүй байна. (СЕХ)

Мянганы Хөгжлийн 3 дахь зорилт

Монгол улс Мянганы Хөгжлийн 3 дахь зорилтод Эмэгтэйчүүдийн улс төр болон шийдвэр гаргах түвшин дэх оролцоог 2015 он гэхэд 30 хувьд хүргэнэ гэсэн зорилт тавьсан.

2011 онд УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 27,2-т “Нам, эсвлээс... нэр дэвшиж байгаа хүний 20-оос доошгүй хувь нь эмэгтэйчүүдийн төлөөлөл байна” гэж зааснаар 2012 оны Улсын Их Хурлын сонгуульд 11 нам, 2 эвсэл, бие даагч нийт 544 нэр дэвшигч бүртгэгдсэн бөгөөд үүнээс 26 тойрогт нийт 354 нэр дэвшигчээс 84 эмэгтэй, жагсаалтаар 190 нэр дэвшигчээс 90 эмэгтэй тус тус өрсөлдсөн. Өнөөдөрийн байдлаар УИХ-д 11 эмэгтэй гишүүн сонгогдон ажиллаж байна.

№	Монгол Улсын Мянганы Хөгжлийн зорилтын шалгуур үзүүлэлтийг тооцох аргачлал	1990	2000	2004	2008	2012	2015
3,5	Улсын Их Хуралд сонгогдсон эмэгтэйчүүдийн эзлэх хувь	24,9 ^а	11,8 ^а	6,6 ^а	3,9 ^б	14,47 ^б	30,0 ^а
3,6	Улсын Их Хуралд нэр дэвшсэн эмэгтэйчүүдийн эзлэх хувь	7,7 ^а (1992)	10,9 ^а	13,7 ^а	18,5 ^б	32,0 ^б	30,0 ^а

Эх сурвалж:

а. УИХ-ын тогтоол #13. Монгол Улсын МХЗ-уудыг батлах тухай. 2008 он.

б. СЕХ, ҮСХ, 2008, 2012

Парламент дахь эмэгтэйчүүд

Улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцоо, хувь нэмэр нь хүний хөгжил, ардчилсан засаглалын урьдчилсан нөхцөл болдог. Азийн, Номхон далайн бүс нутагт дэлхийн нийт хүн амын гуравны хоёр нь амьдарч, сүүлийн жилүүдэд эдийн засаг нь үсрэнгүй хөгжсөн боловч тус бүс нутгийн олон улс оронд улс төр дэх жендерийн тэгш байдал хангагдаагүй хэвээр байна. Азийн орнуудын Хууль тогтоох байгууллагын нийт суудлын 18.0 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна гэсэн үзүүлэлттэйгээр тус бүс нутаг эмэгтэйчүүдийн оролцооны хувьд дэлхийн түвшинд доороосоо гуравт жагсаж байна.

	Нэг танхимтай, Парламентын доод танхимтай орнууд	Парламентын дээд танхим, Сенаттай орнууд	Дундаж
Скандинавын орнууд	42.0%	---	---
Америк тив	23.8%	24.6%	24.0%
Европ – ЕАБХАБ-ын гишүүн орнууд (Скандинавын орнууд)	23.6%	21.1%	23.1%
Европ – ЕАБХАБ-ын гишүүн орнууд (Скандинавын орнууд орохгүй)	21.9%	21.1%	21.7%
Африк тив	20.8%	17.4%	20.4%
Ази	18.5%	14.2%	18.0%
Арабын орнууд	14.9%	6.4%	13.2%
Номхон далайн орнууд	12.7%	34.8%	15.2%

Эх сурвалж: *Парламент дахь эмэгтэйчүүд. Олон улсын Парламентын холбоо.*

<http://www.ipu.org/wmn-e/world.htm> (2012 оны 12 дугаар сарын 19-ны өдөр)